



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 11-ний өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

### “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ”

Компанийн тухай хуулийн 60.1, 60.2, 76.1, 80.2 дахь хэсгүүд болон “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд танхимаар зохион байгуулж, хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
- “Сүү” ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Өнөөдөр сонин, “MNC” телевизийн эфир, компанийн болон “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд мэдээлж, Хурлын зарыг олон нийтэд анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа 2024 оны 04 сарын 01-ний өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүргэлийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дуусталх хугацаанд “Сүү” ХК-ийн байранд, Хурал зохион байгуулагдах өдөр буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 15:00 цаг хүртэл “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд тус тус баталсан маягтын дагуу цаасаар болон [www.survey.suu.mn](http://www.survey.suu.mn) цахим хуудсаар цахим хэлбэрээр бүртгэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. “Сүү” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ийн хэлэлцэж буй асуудлаар “Санал хураалт”-ыг баталсан маягтын дагуу цаасан хэлбэрээр болон [www.survey.suu.mn](http://www.survey.suu.mn) цахим хуудсаар тодорхой өгөгдлийн дагуу цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд Санал авах сүүлчийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр ээлжит хурлын санал хураалт зохион байгуулах үе шатын саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацаагаар тогтоосугай.

7. "Сүү" ХК-ийн "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-д оролцох Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №1 ёсоор, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ын дэгийг Хавсралт №2 ёсоор, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ын зарын төслийг Хавсралт №3 ёсоор, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ын ирцийн бүртгэл болон санал авах хуудасны загварыг Хавсралт №4 ёсоор, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-ын тооллогын комиссын тогтоолын төслийг Хавсралт №5 ёсоор, "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал"-аас гарах шийдвэрийн төслийг Хавсралт №6 ёсоор тус тус баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдэд холбогдох баримт бичигтэй тус компанийн [www.suu.mn](http://www.suu.mn) цахим хуудсанд хандан эсвэл өөрийн харилцагч Үнэт цаасны компаниар дамжуулан танилцаж болохыг мэдэгдсүгэй.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын болон хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн гишүүн С.Сүхболд, хурал зохион байгуулах комиссын гишүүнээр Б.Ариунболд, Б.Хишигжаргал, Г.Баярбаатар, Б.Энхжаргал нарыг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын даргаар иргэн Т.Дамдинсүрэн, гишүүнээр иргэн Ц.Бор-Охин, хөндлөнгийн аудитор "Нексия Глобал Монголиа" аудитын Бизнес хөгжил хариуцсан захирал Н.Ууганбаяр нарыг тус тус томилсугай.

11. Тооллогын комисс Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсгийг удирдлага болгон ажилласугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцогчийг цахим хуудсаар бүртгэх, хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программ хангамж бүхий, зохих ажлын туршлагатай мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР

**“СҮҮ” ХК-ИЙН “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д ОРОЛЦОХ ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧИГ**

“Сүү” ХК-ийн 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулахтай холбогдуулан тус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд Компанийн тухай хуульд заасан болон дараах баримт бичгийг танилцуулна. Үүнд:

○ “Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2024.03.11-ний өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай” тогтоол болон тогтоолын хавсралтууд:

- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг,
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар,
- ✓ “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын ирцийн бүртгэл болон хэлэлцэх асуудлаар санал авах хуудасны загвар,
- ✓ Тооллогын комиссын тогтоолын төслүүд,
- ✓ “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-аас гарах шийдвэрийн төслүүд:
  - Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай,

-----oOo-----

**2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 24-НИЙ ӨДӨР ХУРАЛДАХ “СҮҮ” ХК-ИЙН  
“ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ”-ЫН ДЭГ**

1. Хурлын ирц бүртгэх, /30 минут/
2. Хурлын ирц мэдээлэх, /1 минут/
3. Хурлыг нээлт, /5 минут/
4. Хэлэлцэх асуудал №1: Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал, /60-90 минут/,
  - Компанийн үйл ажиллагааны тайлан,
  - Компанийн санхүүгийн тайлан,
  - Компанийн санхүүгийн тайлан,
  - Хөндлөнгийн аудиторын 2023 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт,
  - “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын 2023 оны үйл ажиллагааны тайлан,
  - Компанийн дотоод аудит, түүний тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт,
  - Гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын гүйцэтгэлийн шалгуур,
  - Компанийн засаглалын кодексын хэрэгжилт,
  - “Сүү” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт,
5. Хэлэлцэх асуудал №2: “Сүү” ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,  
тухай асуудал, /5 минут/,
10. Хувьцаа эзэмшигчдээс асуулт, санал, хүсэлт хүлээн авах, /10 минут/,
11. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуулт, санал, хүсэлтэд хариулах, /10-15 минут/,
12. Хурлаар хэлэлцэж буй асуудлаар санал хураалт зохион байгуулах, /20 минут/,
13. Хурлын завсарлага /15-20 минут/
14. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах, /5-10 минут/
15. Хурлыг хаах /5 минут/



## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Сүү” ХК-ийн 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2024 оны 04 сарын 24-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд танхимаар зохион байгуулна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
- “Сүү” ХК-ийн 2023 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх,

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр нь 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байна.

Хувьцаа эзэмшигч та ээлжит хуралд оролцохын тулд 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр дуустал хугацаанд “Сүү” ХК-ийн байранд, Хурал зохион байгуулагдах өдөр буюу 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 15:00 цаг хүртэл “Холидэй Инн” зочид буудлын хурлын танхимд тус тус баталсан маягтын дагуу цаасаар болон [www.survey.suu.mn](http://www.survey.suu.mn) цахим хуудсаар цахим хэлбэрээр бүртгүүлнэ.

“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ийн хэлэлцэж буй асуудлаар санал хураалтыг баталсан маягтын дагуу цаасан хэлбэрээр болон [www.survey.suu.mn](http://www.survey.suu.mn) цахим хуудсаар тодорхой өгөгдлийн дагуу цахим хэлбэрээр зохион байгуулах бөгөөд Санал авах сүүлчийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр ээлжит хурлын санал хураалт зохион байгуулах үе шатын саналын хуудас хүлээн авах сүүлийн хугацаагаар тогтооно. *IXэрэв өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй тохиолдолд хувьцаа эзэмшигч та саналаа санал авах баталсан маягтын дагуу цаасан хэлбэрээр бөглөн шуудангаар, Сүү ХК-ийн байранд өөрийн биеэр, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, өөрийн харилцагч Үнэт цаасны компани /УЦК/-р дамжуулан тус тус өгөх байдлаар урьдчилан хүргүүлэх боломжтой. Хурлын ирц цаасан хэлбэрээр бүртгүүлэх эсхүл саналын хуудсаар цаасан хэлбэрээр саналаа өгөх тохиолдолд тухайн маягтыг бүрэн гүйцэд, үнэн, зөв, засваргүй, баллаагүй бөглөн, иргэний үнэмлэхний хуулбар буюу нотлох баримтыг хавсаргасан байх ёстойг анхаарна уу./*

Хувьцаа эзэмшигч та холбогдох баримт бичигтэй тус компанийн [www.suu.mn](http://www.suu.mn) цахим хуудсанд хандан эсвэл өөрийн харилцагч Үнэт цаасны компаниар дамжуулан танилцаж, холбогдох мэдээллийг хурал зохион байгуулах комиссоос доорх хаягаар долоо хоногийн Даваагаас Баасан гаригуудад ажлын цагаар холбогдож авч болно. Үүнд:

Харилцах утас: 88062481 /Г.Баярбаатар/, 89038286 /Б.Энхжаргал/,  
Цахим шуудангийн хаяг: [survey@mongolmilk.mn](mailto:survey@mongolmilk.mn)  
Шуудангийн хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, Сүү ХК, 2077108 ш/х-27

Хувьцаа эзэмшигчид хурлын үеэр санал хэлж, асуулт асуухдаа хурлын дэгийн дагуу тогтоосон хугацаанд асуух ёстойг анхаарна уу.

Жич: Хэрэв хувьцаа эзэмшигч нь өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.



## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРЛЫН ИРЦИЙН БҮРТГЭЛ

Хувьцаа эзэмшигч / хувь хүн бол овог, нэр, хуулийн этгээд ол оноосон нэр бичих/:

Регистрийн дугаар: .....

Эзэмшиж буй хувьцааны төрөл: .....

Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг: .....

**Хурлын ирцийн баталгаажилт:** “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигч би 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт хуралдах “Сүү” ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд оролцох бүртгэлээ баталгуулж байна. /Хурлын бүртгэлийг баталгаажуулж буй этгээдийн тохирох бүртгэлийг сонгон уу./

- Хувь хүн /Өөрийн биеэр/,
- Хуулийн этгээдийн төлөөлөгч,
- Итгэмжлэгдсэн төлөөлөгч

### Бүртгэл, санал өгөх нөхцөл:

- Саналыг цахим хэлбэрээр өгөх ба тухайн санал нь хүчин төгөлдөр болохыг үүгээр баталгаажуулав. /Нууц үг хүлээн авах утасны дугаар: .....
- “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигч би 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт хуралдах “Сүү” ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд оролцох бүртгэлээ баталгуулж байна. Саналыг цаасан хэлбэрээр хүргүүлэх ба тухайн санал нь хүчин төгөлдөр болохыг үүгээр баталгаажуулав.

*Жич: Саналаа цахим хэлбэрээр өгөх сонголтыг сонгосон тохиолдолд хувьцаа эзэмшигчийн бүртгүүлсэн утасны дугаараар 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр цахим хэлбэрээр санал өгөх хаяг болон нэвтрэх нууц үгийг хурал зохион байгуулагчийн зүгээс илгээх бөгөөд тухайн нууц дугаарын нууцлалыг хадгалах, мөн утасны дугаарыг үнэн зөв бөглөөгүйгээс үүсэх аливаа эрсдэлийг хувьцаа эзэмшигч өөрөө хариуцах болохыг анхаарна уу.*

*Хавсаргах баримт бичиг: Хувь хүн бол иргэний үнэмлэх, иргэний үнэмлэхийн лавлагаа, гадаад паспортын эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, Гүйцэтгэх удирдлагын иргэний үнэмлэх эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар буюу холбогдох нотлох баримт /аль боломжтой/-ыг хавсаргана.*

Хувьцаа эзэмшигч: ..... /...../

20.. оны ...-р сарын ... өдөр

**“СҮҮ” ХК-ИЙН “ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛ”-Д САНАЛ АВАХ ХУУДАС**

Энэхүү санал авах хуудсаар 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-24 хаягт орших, “Холидэй Инн” зочид буудлын байранд хурлын танхимд танхимаар хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

Хувьцаа эзэмшигчийн овог: ..... нэр.....  
 Регистрийн дугаар: .....  
 Санал өгөх хувьцааны тоо: .....  
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн,

№	Санал өгөх асуудлын агуулга	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай			

**Санал авах хуудсыг ашиглах санамж:**

1. Та санал авах хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓,+ эсвэл **санал өгч буй хувьцааны тоо ширхэгийн** тэмдэглэгээг хийнэ үү.
2. Санал авах хуудсыг засварласан, балласан, бүрэн гүйцэд, зөв бөглөөгүй тохиолдолд санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч, итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хуралд оролцож чадахгүй тохиолдолд урьдчилсан байдлаар өөрийн харилцагч Үнэт цаасны компани /ҮЦК/ дээр очиж эсхүл Suu.mn цахим хаягт хандан хурлын материалтай танилцах боломжтой ба саналаа санал авах баталсан маягтын дагуу цаасан хэлбэрээр бөглөн шуудангаар, Сүү ХК-ийн байранд өөрийн биеэр, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр, өөрийн харилцагч Үнэт цаасны компани /ҮЦК/-р дамжуулан өгөх эсхүл www.survey.suu.mn цахим хаягаар цахим хэлбэрээр бүртгүүлэн, саналаа цахим хэлбэрээр өгөх боломжтой.
5. Шуудангийн хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 29-р хороо, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37, 2077108 ш/х-27

Санал өгсөн хувьцаа эзэмшигч: ..... /Гарын үсэг/

Брокер /ҮЦК-аар дамжуулан санал өгсөн бол/: ..... /Гарын үсэг, тэмдэг/

Санал өгсөн огноо: 20.... оны .... сарын .... өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон:

Тооллогын комиссын дарга: ..... /...../

Санал авах хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

.....

## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

### ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын ирцийг хурлын даргад МЭДЭЭЛЭХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байсныг дурдсугай.

2. Бүртгэлийн өдрөөр “Сүү” ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо ..... ширхэг байснаас 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д ..... саналын эрхтэй, нийт ..... хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц .....% болж, хурлын ирц бүрдсэнийг мэдэгдсүгэй.

Тооллогын комиссын

дарга: .....

Гишүүд: .....

.....



## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 24-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

### САНАЛ ХУРААЛТЫН НЭГДСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3 дахь хэсэг, “Сүү” ХК-ийн 2024 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д санал хураалтаар хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон саналын эрхтэй нийт ..... ширхэг хувьцааны .....% буюу ..... ширхэг хувьцаа эзэмшиж буй .... хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлснээс ..... ширхэг хувьцаа эзэмшиж буй ..... хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүчин төгөлдөрт тооцсугай.

2. Ердийн журмаар санал өгөх хувьцааны тоог ..... ширхэгээр тогтоосугай.

3. Саналын хуудсаар “Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” асуудлаар хуралд оролцож байгаа саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн .... % зөвшөөрсөн, ..... % татгалзсан, ..... % түтгэлзсэн байгааг мэдэгдсүгэй.

1. Зөвшөөрсөн		2. Татгалзсан		3. Түтгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
.....	....%	.....	....%	.....	...%

Тооллогын комиссын  
дарга:

..... / .....

Гишүүд:

..... / .....

..... / .....

“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн  
2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн  
№02 тоот Тогтоолын хавсралт №6

Төсөл

## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 24-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

### 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн №02 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

3. “Сүү” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

С.СҮХБОЛД